

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/08/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Авирмэд

Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

САГИЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.ТӨГСӨӨ ТАНАА

2023.02.16 № УВА-2023/08/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	10
4. Аудитын тайлан.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. Аудитын илрүүлэлт	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	616,995.00	1,054,995.00
35	БАРАА МАТЕРИАЛ	616,995.00	1,054,995.00
35400	Хангамжийн материал	616,995.00	1,054,995.00
35410	Бичиг хэргийн материал	169,000.00	57,000.00
35420	Аж ахуйн материал	447,995.00	997,995.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,925,439.47	7,493,223.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,925,439.47	7,493,223.92
39200	Биет хөрөнгө	14,925,439.47	7,493,223.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,229,930.30	12,229,930.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,528,741.29	-7,643,706.45
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	8,530,000.00	8,530,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,311,999.93	-5,622,999.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	250,000.00	250,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-243,749.61	-250,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,542,434.47	8,548,218.92
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,542,434.47	8,548,218.92
51	Засгийн газрын хувь оролцоо	15,542,434.47	8,548,218.92
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,870,196.00	4,870,196.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	4,870,196.00	4,870,196.00
51200	Хуримтлагдсан үр дүн	10,672,238.47	3,678,022.92
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,434,050.61	10,672,238.47
51220	Тайлант үеийн үр дүн	12,106,289.08	-6,994,215.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,542,434.47	8,548,218.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	88,569,030.30	74,208,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,329,930.30	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,329,930.30	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,329,930.30	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,229,930.30	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	76,239,100.00	74,208,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815,000.00	370,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	815,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	370,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	75,424,100.00	73,838,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,424,100.00	73,838,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	76,462,741.22	81,202,315.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	76,462,741.22	81,202,315.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,311,471.89	73,404,292.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,738,240.00	44,294,012.32

210101	Үндсэн цалин	32,185,040.00	31,741,013.32
210104	Урамшуулал	12,553,200.00	12,552,999.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,771,330.67	5,481,544.98
210201	Тэтгэврийн даатгал	4,004,296.11	3,773,413.78
210202	Тэтгэмжийн даатгал	447,352.40	442,910.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	357,881.94	354,327.88
210204	Ажилгүйдлийн даатгал	89,058.42	83,567.15
210205	Эрүүл мэндийн даатгал	872,741.80	827,326.03
2104	Хангамж, бараа материалын зардал	3,947,600.00	4,485,400.00
210401	Бичиг хэрэг	475,200.00	632,250.00
210402	Тээвэр, шатахуун	3,472,400.00	3,853,150.00
2107	Томилолт, зочны зардал	895,000.00	772,000.00
210702	Дотоод албан томилолт	895,000.00	772,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	346,060.00	243,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	103,060.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	144,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	99,000.00	99,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,613,241.22	18,128,335.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,788,500.00	2,056,120.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,260,000.00	8,640,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,564,741.22	7,432,215.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,151,269.33	7,798,022.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,313,200.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,838,069.33	7,798,022.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,838,069.33	7,798,022.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	12,106,289.08	-6,994,215.55
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	12,106,289.08	-6,994,215.55

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	76,339,100.00	74,208,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,000.00	370,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.00	370,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	370,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	370,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	76,239,100.00	73,838,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	815,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	75,424,100.00	73,838,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,424,100.00	73,838,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	73,839,100.00	74,208,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	73,839,100.00	74,208,100.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,687,830.67	66,410,077.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,738,240.00	44,294,012.32
210101	Үндсэн цалин	32,185,240.00	28,636,007.98
210102	Нэмэгдэл	0.00	3,105,005.57
210104	Урамшуулал	12,553,000.00	12,552,998.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,771,330.67	5,481,544.98
210201	Тэтгэврийн даатгал	4,004,296.11	3,773,413.78
210202	Тэтгэмжийн даатгал	447,352.40	442,910.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	357,881.94	354,327.88
210204	Ажилгүйдлийн даатгал	89,058.42	83,567.15
210205	Эрүүл мэндийн даатгал	872,741.80	827,326.03
2104	Хангамж, бараа материалын зардал	3,888,700.00	4,153,650.00
210401	Бичиг хэрэг	632,200.00	520,250.00
210402	Тээвэр, шатахуун	3,256,500.00	3,633,400.00
2107	Томилолт, зочны зардал	895,000.00	772,000.00
210702	Дотоод албан томилолт	895,000.00	772,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	346,060.00	243,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	103,060.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	144,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	99,000.00	99,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,048,500.00	11,465,870.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,788,500.00	2,825,870.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,260,000.00	8,640,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,151,269.33	7,798,022.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,313,200.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,838,069.33	7,798,022.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,838,069.33	7,798,022.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,500,000.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,500,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,500,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,500,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,500,000.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,500,000.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	4,870,196.00	0.00	-1,434,050.61	3,436,145.39

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,870,196.00	0.00	-1,434,050.61	3,436,145.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	12,106,289.08	12,106,289.08
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,870,196.00	0.00	10,672,238.47	15,542,434.47
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,870,196.00	0.00	10,672,238.47	15,542,434.47
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,870,196.00	0.00	10,672,238.47	15,542,434.47
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-6,994,215.55	-6,994,215.55
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,870,196.00	0.00	3,678,022.92	8,548,218.92

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	73,838,100.00	66,410,077.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	73,838,100.00	66,410,077.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,338,100.00	66,410,077.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,165,600.00	44,294,012.32
210101	Үндсэн цалин	35,612,600.00	28,636,007.98
210102	Нэмэгдэл	0.00	3,105,005.57
210104	Урамшуулал	12,553,000.00	12,552,998.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,020,700.00	5,481,544.98
210201	Тэтгэврийн даатгал	4,094,100.00	3,773,413.78
210202	Тэтгэмжийн даатгал	481,600.00	442,910.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	385,300.00	354,327.88
210204	Ажилгүйдлийн даатгал	96,300.00	83,567.15
210205	Эрүүл мэндийн даатгал	963,400.00	827,326.03
2104	Хангамж, бараа материалын зардал	4,540,000.00	4,153,650.00

210401	Бичиг хэрэг	640,000.00	520,250.00
210402	Тээвэр, шатахуун	3,633,400.00	3,633,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	266,600.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	1,080,400.00	772,000.00
210702	Дотоод албан томилолт	1,080,400.00	772,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	508,400.00	243,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	193,400.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	144,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	99,000.00	99,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,023,000.00	11,465,870.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,023,000.00	2,825,870.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,000,000.00	8,640,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	73,838,100.00	66,410,077.30
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	73,838,100.00	66,410,077.30
320001	Орон нутгийн төсвөөс	73,838,100.00	66,410,077.30
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	370,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	370,000.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	5.00	5.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	2.00	2.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	1.00	1.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2.00	2.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1.00	1.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бие даан зохион байгуулах гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.

- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Сагил сумын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,493.2 мянган төгрөгөөр буюу 50 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	616.9	1,054.9	438.0
Үндсэн хөрөнгө	14,925.4	7,493.2	-7,432.2
Нийт хөрөнгө	15,542.4	8,548.2	-6,994.2
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	15,542.4	8,548.2	-6,994.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,542.4	8,548.2	-6,994.2

Бараа материалын дансны үлдэгдэл 1,054.9 мянган төгрөг болж 438.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа материал худалдан авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,493.2 мянган төгрөг болж 7,432.2 мянган төгрөгөөр буурсан нь машин тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдлээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,548.2 мянган төгрөг болж 6,994.2 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 76,500.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 76,500.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,253.5 мянган төгрөгөөр өсгөж 77,753.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалингийн сан, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 73,838.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 73,838.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 73,838.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 66,410.1 мянган төгрөгийг зарцуулж, 7,428.0 мянган төгрөгийг хэмнэж, хөрөнгийн дуудлага худалдааны дэнчингийн орлого 370.0 мянга нийт 7,798.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 66,410.1 мянган төгрөг буюу 90 хувьтай байгаа нь зардлыг 7,798.0 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Үндсэн үйл ажиллагааны зардал-80101	54,999.6	49,155.8	5,843.8	89%
2	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Мэдээлэл сурталчилгааны зардал- 80205	193.4	0	193.4	0%
3	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Ажил олгогчоос олгох тэтгэмж-80802	500.0	0	500.0	0%
4	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Багийн ИНХ-ын даргын урамшуулал-80825	14,122.1	14,058.4	63.7	99.9%
5	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх-82201	4,023.0	2,825.9	1,197.1	70%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2022 онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого зарлагын гүйлгээ гараагүй болно.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 81.2 сая төгрөгийн 2.0 хувь буюу 1.6 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 1.3 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	24.0	1	24.0	100
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  Б.АВИРМЭД/

2023 оны 02 сарын 16-ны өдөр